Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хүснэгт:

| Д/д | БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ | ТӨСӨВ | ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | СУУРЬ ТҮВШИН | ЗОРИЛТОТ ТҮВШИН | ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ | ХУВЬ |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **Зорилт 1.1** Иргэдэд зориулсан спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 2.2.3/ | | - | Ажлын явц, хувь | Спорт цогцолборын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан. | Спортын цогцолборын зураг төсөл хийлгэнэ. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 8 дугаар хороонд 586 үзэгчийн суудал бүхий "Спорт цогцолборын барилга"-ын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээг "Классик хаус" ХХК гүйцэтгэж загвар зураг батлагдах шатанд хэрэгжиж байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 12 дугаар хороонд гүйлтийн зам бүхий иж бүрэн сагсан бөмбөгийн талбайн ажил хийгдэж байгаа бөгөөд ажлын явц 70 хувьтай. Нийгмийн хариуцлагын хүрээнд Хаан банкнаас дүүргийн 12 дугаар хороонд 3x3 сагсан бөмбөгийн талбайг байгуулж байна. | 70% |
| 1 | Спортын цогцолборын барилгын зураг төсөл, төсвийг хийлгэн, барилга | 200.0 /ДТХО/ | Зураг төсөв хийлгэж, санал уламжилсан | Спорт цогцолборын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийг | Спортын цогцолборын зураг төсөл, төсвийг хийлгэж, | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 8 дугаар хороонд 586 үзэгчийн суудал бүхий "Спорт цогцолборын барилга"-ын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээг "Классик хаус" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд сагсан бөмбөг, бокс, ресторан, фитнес, | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | угсралтад шаардагдах хөрөнгийг улс, нийслэл, дүүргийн төсөвт тусгуулахаар санал хүргүүлнэ. | | эсэх, ажлын явц, хувь | сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан. | төсөвт тусгуулахаар санал уламжилсан байна. | хурлын заал, ширээний теннис, ханын теннис, байт харваа, усанд сэлэлт, шатар даам, бөхийн танхимууд болон бусад дагалдах өрөө тасалгаануудтайгаар төлөвлөгдсөн. Загвар зураг батлагдах шатанд хэрэгжиж байна. | |
| **Зорилт 1.2** Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын түвшинг үе шаттайгаар өсгөнө. /ЗГҮАХ 2.3.9.2/ | | - | Ашиглалтад орсон цэцэрлэгийн тоо, ажлын явц, хувь | ДТХО-аар хэрэгжих 2 цэцэрлэг гэрээ байгуулагдсан. | 3-аас доошгүй цэцэрлэгийн барилгын ажлыг дуусгана. | • Дүүргийн 23 дугаар хороонд 300 ор бүхий нэг цэцэрлэг шинээр ашиглалтад оруулсан.<br>• Барилгын ажил явагдаж байгаа 1150 ор бүхий 6 цэцэрлэгийн барилгын ажлын явц /5-95 хувь/<br>• Гүйцэтгэгч шалгарч, зураг төсвийн шатанд байгаа 1000 ор бүхий 6 цэцэрлэгийн барилга<br>• Тендерийн шатанд байгаа 640 ор бүхий 3 цэцэрлэгийн барилга<br>• Хэрэгжүүлэхээр төсөвт тусгагдсан болович тендер зарлагдаагүй 1320 ор бүхий 9 цэцэрлэг болон бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга байна. Нийт 7620 суудал бүхий 7 сургууль, 4410 ор бүхий 25 цэцэрлэгийн барилга барихаар төлөвлөж, төсөвт тусгагдсан. | 70% |
| 2 | Шинээр 3-аас доошгүй цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулна. | 5,944.0 /ДТХО/ | Ашиглалтад орсон цэцэрлэгийн тоо, ажлын явц, хувь | ДТХО-аар хэрэгжих 2 цэцэрлэг гэрээ байгуулагдсан. | 3-аас доошгүй цэцэрлэгийн барилгын ажил дууссч, ашиглалтад орсон байна. | Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй дараах ажлууд байна. Үүнд:<br>Барилгын ажил эхэлсэн /5/<br>- 4 дүгээр хороо Хангарьд сити 2 хотхонд 300 ор бүхий Цэцэрлэгийн барилга худалдан авсан. /Ажлын явц 100 хувь/<br>- 3 дугаар хороо, 240 ор бүхий 4-р цэцэрлэгийн барилга угсралтын ажил хийгдсэн. /Ажлын явц 95 хувь/<br>-13 дугаар хороонд баригдаж буй 180 суудал, 120 ор бүхий бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга угсралтын ажил хийгдэж дууссан. Дотор засал, гадна тохижилтын ажил хийгдэж байна. /Ажлын явц 75 хувь/<br>- 5 дугаар хороо, 150 ор бүхий 71-р цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн карказ цутгалтын ажил хийгдэж дууссан. /Ажлын явц 30 хувь/<br>- 9 дүгээр хороо 240 ортой 134-р цэцэрлэгийн барилгын карказ угсралт, дүүргэлт, дотор өрлөгийн ажил хийгдсэн. Дулаан, цахилгааны | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шугам сүлжээний ажил хийгдэж байна. /Ажлын явц 45 хувь/,<br>Зураг төсвийн шатанд байгаа /5/<br>-2 дугаар хороонд баригдах 120 ортой 67 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчээр "Кенжикү" ХХК шалгарсан. Зураг төсөв батлагдах шатанд байна.<br>-1 дүгээр хороонд баригдах 240 ортой цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгчээр "Гранпаскал" ХХК шалгарсан. Зураг төсөв батлагдах шатанд байна.<br>-4 дүгээр хороонд баригдах 100 ортой 145 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчээр "Халзан хайрхан" ХХК шалгарсан. Зураг төсвийн шатанд байна.<br>-20 дугаар хороонд баригдах 240 ортой цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгчээр "Болд" ХХК шалгарсан, эскиз зураг боловсруулагдаж байна.<br>-10 дугаар хороо 49 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчээр "Гегатера тех" ХХК шалгарсан, зураг төсөв боловсруулагдаж байна.<br>Худалдан авах ажиллагааны болон тендерийн баримт бичиг боловсруулж байгаа /6/<br>- 4 дүгээр хороо, Ханбогд хотхонд 200 ор бүхий цэцэрлэг худалдан авах ажлын тендер зарлагдсан, аж ахуй нэгж материал ирүүлээгүй байна.<br>-18 дугаар хороонд баригдах 200 ортой цэцэрлэгийн барилгын тендер зарласан, үнэлгээ хийгдэж байна.<br>-4 дүгээр хороонд баригдах бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын тендер зарлагдаагүй байна.<br>-8 дугаар хороонд баригдах бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын тендер зарлагдаагүй байна.<br>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй дараах ажлууд байна. Үүнд:<br>-9, 12, 14, 16 дугаар хороонд шинээр 5 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | барихаар төлөвлөсөн. Тендер зарлагдаагүй байна.<br>-4 дүгээр хороонд 240 ортой цэцэрлэгийн барилгын ажлын тендер зарласан, үнэлгээ хийгдэж байна.<br>-8 дугаар хороонд 240 ортой цэцэрлэгийн барилгын ажлын тендер зарлагдаагүй байна.<br>-9 дүгээр хороонд 240 ортой цэцэрлэгийн барилгын ажлын тендер зарлагдаагүй байна.<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй дараах ажлууд байна. Үүнд:<br>-4-р хороонд баригдах 200 ор бүхий цэцэрлэгийн барилгын дүүргэлт, цахилгаан, дээврийн цутгалтын ажил дууссан, гадна фасадын будгийн ажил, гадна тохижилтын ажил хийгдэж байна. /Ажлын явц 70 хувь/<br>-16 дугаар хороонд баригдах 200 ортой цэцэрлэгийн газар шорооны ажил хийгдэж байна. /Ажлын явц 5 хувь/<br>-15-р хороонд баригдах 200 ортой цэцэрлэгийн гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан, зураг төсөв батлагдаж, техникийн нөхцөлүүд гарсан.Барилгын ажил эхлэх шатанд байна | |
| **Зорилт 1.3** Гэр хорооллын өрхүүдийн ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 3.7.11/ | | - | Ашиглалтад орсон худгийн тоо | ДТХО-аар хэрэгжих 5 худгийн гэрээ байгуулагдсан. | 5-аас доошгүй худгийн барилга ашиглалтад орсон байна. | Дүүргийн хэмжээнд 2 гүний худаг ашиглалтад орсон, 9, 12, 13, 14 дүгээр хороонд 5 гүний худаг өрөмдлөгийн шатанд хэрэгжиж байна. | 90% |
| 3 | Гэр хорооллын шаардлагатай байршлуудад 5-аас доошгүй ундны усны худгийг ашиглалтад оруулна. | 240.0 /ДТХО/, 60.0 /ДОНХС | Ашиглалтад орсон худгийн тоо | ДТХО-аар хэрэгжих 5 худгийн гэрээ байгуулагдсан. | 5-аас доошгүй худгийн барилга ашиглалтад орсон байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 9, 12, 13, 14 дүгээр хороонд 5 гүний худаг гаргах ажил өрөмдлөгийн шатанд хэрэгжиж байна.<br>Он дамжин хэрэгжсэн 12, 13 дугаар хороонд 2 гүний худаг гаргаж, ашиглалтад оруулсан.<br>Нийслэлийн орон нутгийн сангийн хөрөнгөөр "Гүний худгуудыг ухаалаг төхөөрөмж суурилуулах ажил /ХУД, 13 дугаар хороо/ төсөл арга хэмжээний хүрээнд 6 гүний худагт смарт төхөөрөмж суурилуулах ажлыг Баялаг говь ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 2022 оны 06 дугаар сарын 13-ны | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрийн байдлаар бараа материал татаж авсан, магадлалын дүгнэлт хүлээгдэж байна.<br>Дүүргийн 9 дүгээр хороонд смарт ажиллагаатай 1 худаг шинээр ашиглалтад оруулахаар худгийн өрөмдлөгийн ажил хийгдэж байна. 2022 онд дүүргийн хэмжээнд смарт ажиллагаатай 7 худгийг ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. | |
| **Зорилт 1.4** Хороолол дундах зам талбайн ус зайлуулах сувгууд болон үерийн далан хамгаалалтыг шинээр бий болгоно. /ЗГҮАХ 3.7.12/ | | - | Зураг төсөв хийлгэж, төсөвт санал уламжилсан эсэх, ажлын явц, хувь | Нисэхт 2 байршилд үерийн далан сувгийн зураг төсөв хийлгэхээр гэрээ байгуулагдсан. | Шаардлагатай 2 байршилд зураг төсөв хийлгэж, төсөвт тусгуулахаар санал уламжилсан байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр Нисэхийн бүсэд /9 , 10, 16 дугаар хороо/ үерийн ус зайлуулах шугам сүлжээний зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхээр "Гидро дизайн иноваци" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд ажлын зураг батлагдаж магадлал хийгдэж байна. Ажлын явц 90 хувьтай.<br>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ дараах ажлыг гүйцэтгэж байна. Үүнд:<br>1. 12-р хороонд 180 метр урт Туул голын далан өндөрлөх, эргийн бэхэлгээ хийх ажил бүрэн хэрэгжиж дууссан.<br>2. 1-р хороо Чимэд-Осорын гудамж орчмын 356 метр урт ус зайлуулах шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажил бүрэн хэрэгжиж дууссан.<br>3. 10-р хороо Нисэхийн үерээс хамгаалах 300 метр урт далан сувгийн засвар, нөхөн сэргээлтийн ажил. Суурь арматурын ажил хийгдэж байна.<br>4. 3-р хороо Ажилчны гудамжнаас Яармагийн гүүр хүртэлх /Шунхлай ШТС/ авто замын ус зайлуулах шугам угсралтын ажил. 2022 оны 07 дугаар 18-ны өдөр эхэлнэ. | 100% |
| 4 | Ус ихээр тогтдог болон үер усны аюулд өртөх эрсдэл өндөртэй газрын судалгааг гаргаж, шаардлагатай байршилд зураг төсөв хийлгэнэ. | 30.0 /ДТХО/ | Зураг төсөв хийлгэж, төсөвт санал уламжилсан эсэх, ажлын явц, хувь | Нисэхт 2 байршилд үерийн далан сувгийн зураг төсөв хийлгэхээр гэрээ байгуулагдсан. | 2 байршилд зураг төсөв хийлгэж, төсөвт тусгуулахаар санал уламжилсан байна. | "Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах" ажлын хүрээнд ус зайлуулах сувгийг өргөтгөж, шинэчлэх, зарим байрлалд шинээр үерийн далан төлөвлөх шаардлагатай байршлуудын судалж Барилга, хот байгуулалтын яаманд санал хүргүүлсэн.<br>Үерийн хамгаалалтын барилга байгууламж, далан, суваг шуудуу хөрсний болон зам талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээний ашиглалтын судалгааг гаргаж Геодези, усны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-т хамтран ажиллах тухай албан хүсэлт хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/320 дугаар захирамжийн дагуу 7 дугаар хороо үерийн ус зайлуулах байгууламж барих, засварлах ажил ус зайлуулах суваг суурилуулах шатанд хэрэгжиж байна.<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр Нисэхийн бүсэд /9 , 10, 16 дугаар хороо/ үерийн ус зайлуулах шугам сүлжээний зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг "Гидро дизайн иноваци" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд магадлал хийгдэж байна.<br>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Геодези усны барилга байгууламжийн газар 1 дүгээр хороо, Чимэд-Осорын гудамжинд 350 урт метр авто замын ус зайлуулах шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэсэн, 3 дугаар хороо, Ажилчны гудамжнаас Яармагийн гүүр хүртэл /Шунхлай ШТС/ авто замын ус зайлуулах шугамын барилга угсралтын ажлыг 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрөөс эхлүүлэхээр ажиллаж байна.<br>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ дүүргийн үерийн хамгаалалтын барилга, байгууламжийн засварын ажлын хүрээнд дүүргийн 12 дугаар хороонд 180 урт метр Туул голын далан өндөрлөх, эргийн бэхэлгээ хийх ажлыг бүрэн гүйцэтгэсэн, 10 дугаар хороо 300 урт метр Нисэхийн ус зайлуулах сувгийг засварлаж, 4 байршилд ус гаргуурыг шинэчлэх ажил суурийн арматурын шатанд хэрэгжиж байна. Мөн нийслэлийн төсвийн хөрөнгөөр 8, 21 дүгээр хороонд Жаргалантын амны 1,8 км урт үерийн хамгаалалтын байгууламжийн ажил 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэхээр бэлтгэл хангагдаж байна. | |
| **Зорилт 1.5** Нийтийн эзэмшлийн зам талбайн болон хогийн цэг, хайрга, дайрга олборлолт, | | - | Суурилуулсан камерын тоо, ажлын явц, хувь | 117 камер суурилуулах ажлын кабель татагдсан. | 300-аас доошгүй байршилд | Дүүргийн хэмжээнд 2022 онд нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 3,2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн гудамж | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| тээвэрлэлтийг хянаж, зохицуулах цэгүүдийн камержуулалтыг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 4.3.2/ | | | | | камержуулсан байна. | талбай, авто зам, хогийн цэгийг камержуулах 6 төсөл арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөгдсөн. | |
| 5 | Дүүргийн хэмжээнд 300-аас доошгүй камер суурилуулж, хуучирч муудсан камеруудыг сэргээн засварлана. | 1,936.2 /ДОНХС/ | Суурилуулсан камерын тоо, ажлын явц, хувь | 117 камер суурилуулах ажлын кабель татагдсан. | 300-аас доошгүй камер суурилуулагдсан байна. | Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны хөрөнгөөр "Арш технологи " ХХК дүүргийн 1-11, 14-21 дүгээр хороодын 38 байршилд 117 ширхэг камер суурилуулах бөгөөд 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар ажлын зураг төсөв батлагдсан, 38 ширхэг шон суурилуулж, 40,000 метр шилэн кабел татсан, ажил 70 хувийн гүйцэттэлтэй хэрэгжиж байна.<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд шинээр хэрэгжих "Хайрга, дайрга олборлолт, тээвэрлэлтийг хянаж зохицуулах цэгүүдийн камержуулалт"-ын ажлын гүйцэтгэгчээр "Сонголт нар" ХХК шалгарсан бөгөөд тус ажлын хүрээнд 12, 13, 14, 16 дугаар хороодод 5 байршилд 10 ширхэг авто машины дугаар таних тусгай зориулалтын камер суурилуулна. 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар ажлын зураг төсөв боловсруулах шатанд хэрэгжиж байна. Дүүргийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих "Хогийн цэгийн камержуулалт "-ын ажлын хүрээнд 88 байршилд 182 ширхэг камер суурилуулах ажлыг гүйцэтгэгчээр "Арш технологи" ХХК шалгарч, гэрээ байгуулахаар ажиллаж байна. | 70% |
| **Зорилт 1.6** Замын хөдөлгөөний нягтралыг сарниулж, ачааллыг тэнцвэржүүлсэн, авто замыг шинээр байгуулна. /ЗГҮАХ 6.1.6/ | | - | Шинээр тавьсан авто замын урт/км | Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8.7 км авто зам тавигдсан. | 5 км-ээс доошгүй хатуу хучилттай авто зам тавигдсан байна. | Улсын төсвийн хөрөнгөөр 16, 17 дугаар хороонд 2,8 км авто зам барих 2 төсөл арга хэмжээ, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 17, 18, 19, 20 дугаар хороонд 3,64 км хатуу хучилттай авто зам тавих ажил хуваарийн дагуу хэрэгжиж байна.<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй 5, 16, 21 дүгээр хороонд 3,1 хатуу хучилттай авто зам барих ажил гэрэлтүүлэг, явган хүний зам тавих шатанд хэрэгжиж байна.<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр Хан-Уул зам, засвар арчлалт ОНӨААТҮГ 2022 онд шинээр 9, 8, 19, 20, 21 дүгээр хорооны 4 байршилд авто зам барих ажлыг хэрэгжүүлэхээс 21 дүгээр хорооны Буянт- | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ухаа 2 хорооллын авто зам, газар шороонь шатанд хэрэгжиж байна. | |
| 6 | Дүүргийн авто замын ачааллыг тэнцвэржүүлэх, зорчих хэсгийг сайжруулах зорилгоор 5 км-ээс доошгүй хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулна. | 4,660.00 /ДТХО/, УНТХО | Шинээр тавьсан авто замын урт/км | Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8.7 км авто зам тавигдсан. | 5 км-ээс доошгүй хатуу хучилттай авто зам тавигдсан байна. | Улсын төсвийн хөрөнгөөр дүүргийн 17 дугаар хороо Хан-Хиллс хотхоноос Зайсангийн гүүр хүртэлх хатуу 1 км авто зам баригдаж байна. Зам барилгын ажлын хүрээнд хөлдөлтөөс хамгаалах үе, авто замын хашлага суурилуулах ажил хийгдэж байна.<br>Улсын төсвийн хөрөнгөөр дүүргийн 16 дугаар хороо Нисэхийн эцсийн автобусны буудлаас Сонсголонгийн төв зам хүртэлх хатуу хучилттай 1,8 км авто замын ажлын гүйцэтгэгчээр "Тэмүүнхолдинг" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Авто замын зураг төсөв боловсруулагдаж байна.<br>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 20 дугаар хороо Номин Юнайтед их дэлгүүрийн баруун талын авто замаас Б.Шаравын гудамж хүртэлх 0.86 км авто зам баригдаж байна. Зам барилгын ажлын хүрээнд инженерийн шугам сүлжээний ажил, хөлдөлтөөс хамгаалах үе, авто замын хашлага суурилуулах ажил хийгдэж байна.<br>Мөн нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд дараах авто замын ажил хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:<br>1. 17-р хороо Эрдэнийн төгөл хотхоны баруун талаас Хүннү хорооллын авто зам хүртэлх 0,18 км авто замын ажлын гүйцэтгэгчээр "Эс Ар Пи инженер консалтинг монголиа" ХХК-тай шалгарч гэрээ байгуулсан.<br>2. 18-р хороо Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбох 0.6 км авто замын ажлын тендерийг 2 удаа зарласан боловч аж ахуйн нэгж байгууллага материал ирүүлээгүй. Тендер дахин зарлагдах шатанд.<br>3. 19-р хороо Ерөнхий боловсролын 115 дугаар сургуулийн баруун талаар Туул гол гудамжийг Б.Шаравын гудамжтай холбох 0,6 км авто замын ажлын тендерийг 2 удаа зарласан боловч аж ахуйн нэгж байгууллага материал ирүүлээгүй. Тендер дахин зарлагдах шатанд. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дүүргийн төсвийн хөрөнгөөр Хан-Уул зам засвар арчлалт ОНӨААТҮГ-ийн 2022 онд шинээр 4 авто замын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:<br>1. 21-р хороо Буянт-Ухаа 2 хорооллын 0,25 км авто зам. Газар шорооны ажил хийгдэж байна.<br>2. 9-р хороо Нисэхийн эцсийн автобусны буудал орчмын авто зам. Авто замын зураг төсөв батлагдсан. Замын ажил 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр эхэлнэ.<br>3. 8-р хороо Сонсголон 8 дугаар гудамж хатуу хучилттай авто зам. Авто замын зураг төсөв батлагдсан. Замын ажил 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдөр эхэлнэ.<br>4. 20-р хороо 27 дугаар цэцэрлэгийн зүүн талаар 70 метр авто зам. Авто замын зураг төсөв батлагдсан. Замын ажил 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр эхэлнэ.<br>Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ 1, 2, 3, 4, 11, 14, 15 дугаар хороодын эвдрэл ихтэй авто замын судалгааг гаргаж, 45 байршилд 450.43 м.кв асфальт бетон нөхөөсний ажлыг гүйцэтгэсэн | |
| **Зорилт 1.7** Явган хүний болон унадаг дугуйн зам, авто машины зогсоол, хүүхдийн тоглоомын талбай барьж байгуулан, тоосжилтыг бууруулна. /ЗГҮАХ 6.1.7/ | | - | Тохижилт хийгдсэн байршлын тоо, шинээр тавьсан явган хүний болон унадаг дугуйн замын урт | 3 тоглоомын талбай, 3.2 км явган хүний зам, Туул голын эрэг дагуу 1.6 км явган хүний болон унадаг дугуйн зам тавьж, 2 авто зогсоол засварласан. | 8-аас доошгүй байршилд тохижилтын ажил хийгдсэн байна. | Улаанбаатар зам, засвар арчлалтын газар ОНӨААТҮГ дүүргийн 19 дүгээр хороо, Богд хааны ордон музейн зүүн талыг хашааг буулгаж, газар чөлөөлсөн талбайд 300 урт метр явган хүний зам, дугуйн зам шинээр тавьж, орчныг тохижуулсан. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Зайсангийн гүүрнээс Маршалын гүүр хүртэл Туул голын арын далан дагуух 2.5 метрийн өргөнтэй 2.4 км урт дугуйн замын ажил 30 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжихээр төлөвлөгдсөн Чингисийн өргөн чөлөөний явган зам, дугуйн замын засвар шинэчлэлтийн ажил "Тусгай замын автобус LRT төсөл"-ийн трасстай давхцаж, тодорхойгүй хугацаагаар зогссон байна.<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд орон сууц хороолол, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эвдрэлтэй 27 байршилд явган хүний зам талбайг засварлах, шинэчлэх ажлын хүрээнд 2, 3, 12, 19, 21 дүгээр хороонд 3046,7 м.кв талбайд явган хүний зам шинээр тавьсан байна.<br>Дүүргийн Засаг даргын 2022 оны А/237 дугаар захирамжаар нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн эвдрэлтэй явган хүний замыг засварлах, чанар, стандартын шаардлагыг хангах төсөв хөрөнгийг шийдвэрлэж, Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлэхээр бэлтгэл хангаж байна. | |
| 7 | Иргэдийн аюулгүй зорчих нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор Чингисийн өргөн чөлөөний явган хүний зам, дугуйн замыг шинэчилнэ. | 1,250.0 /ДТХО/ | Шинэчлэгдсэн явган хүний зам, дугуйн замын урт/км, ажлын явц, хувь | - | 4км-ээс багагүй урт явган хүний болон дугуйн зам шинээр тавьсан байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжихээр төлөвлөгдсөн Чингисийн өргөн чөлөөний явган зам, дугуйн замын засвар шинэчлэлтийн ажил "Тусгай замын автобус LRT төсөл"-ийн трасстай давхцаж, цаашид хэрэгжих боломжгүй болсон. | 0% |
| 8 | Төвийн хороодын нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний замын засвар, тохижилтын ажлыг гүйцэтгэнэ. | 1,398.1 /ДТХО, ДОНХС/ | Засвар, тохижилт хийсэн байршлын тоо | ДТХО-аар 9 байршилд 3.2 км явган хүний зам шинээр тавьсан. | 8-аас доошгүй байршилд засвар, тохижилтын ажил хийгдсэн байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд орон сууц хороолол, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн эвдрэлтэй 27 байршилд явган хүний зам талбайг засварлах, шинэчлэх ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 2, 3, 12, 19, 21 дүгээр хороонд 3046,7 м.кв талбайд явган хүний зам шинээр тавьсан байна.<br>Дүүргийн Засаг даргын 2022 оны А/237 дугаар захирамжаар нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн эвдрэлтэй явган хүний замыг засварлах, чанар, стандартын шаардлагыг хангах төсөв хөрөнгийг шийдвэрлэж, Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлэхээр ажиллаж байна.<br>Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ дүүргийн 2, 3 дугаар хороо, Дунд гол гудамж дагуух авто зам дагуу орц, гарц хэсгүүдийн явган хүний замд стандартын дагуу налуу хийх, Нийслэлийн Хот тохижилтын газар, Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, 61а байрны баруун талд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | явган зорчигч явах боломжгүй байсан нарийн хэсгийг өргөсгөн засварлаж, явган хүний зам тавьж, засварласан. Нийслэлийн хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын хэрэгжүүлж буй 17 дугаар хороо, Смайл дэлгүүрээс Туул голын далан хүртэлх авто зам дагуух явган хүний зам тавих ажил газар чөлөөлөх шатанд хэрэгжиж байна.<br>Улаанбаатар зам, засвар арчлалтын газар ОНӨААТҮГ дүүргийн 19 дүгээр хороо, Богд хааны ордон музейн зүүн талыг хашааг буулгаж, газар чөлөөлсөн талбайд 300 урт метр явган хүний зам, дугуйн зам шинээр тавьж, орчныг тохижуулсан. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Зайсангийн гүүрнээс Маршалын гүүр хүртэл Туул голын арын далан дагуух 2.5 метрийн өргөнтэй 2.4 км урт дугуйн замын ажил 30 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| 9 | Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд /1, 2, 3, 4, 10, 12, 14, 15, 16, 18, 19, 20, 21 дүгээр хороо/ хэрэгжиж буй орчны тохижилтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулж, 1, 2 дугаар хороонд шинээр тохижилт, тоглоомын талбай байгуулах ажлыг хэрэгжүүлнэ. | 1,394.4 /ДТХО/ | Тохижилт хийсэн байршлын тоо | Тохижилтын ажлын гэрээ байгуулагдсан . | 15-аас доошгүй байршилд тохижилтын ажил хийгдсэн байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр “Орчны тохижилт”-ын чиглэлээр 1, 2, 3, 4, 10, 12, 14, 15, 16, 18, 19, 20, 21 дүгээр хороодод он дамжин хэрэгжиж буй 3 төсөл арга хэмжээний хүрээнд 16 ажил 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд шинээр 2 дугаар хороо 7, 8 дугаар байрны ард амралтын талбай, сагсан бөмбөгийн талбай, тоглоомын талбай, авто зогсоол, явган зам, ногоон байгууламж бүхий иргэд, олон нийтэд зориулсан тохижилтын ажил, 1 дүгээр хороо, 14, 15 дугаар хорооны тоглоомын талбайг шинэчлэх, 12 дугаар хороонд шинээр спорт тоглоомын талбай байгуулах ажлыг тус тус хэрэгжүүлж байна.<br>Хаан банктай хамтарч 12 дугаар хороонд олон улсын стандартад нийцсэн 3*3 сагсан бөмбөгийн талбайн барилга угсралтын ажил явагдаж байна. Олон улсын хөлбөмбөгийн холбооны санхүүжилтээр 34 дүгээр сургуулийн гадна талбайд олон улсын стандартад нийцсэн хиймэл зүлэг бүхий хөл бөмбөгийн талбай байгуулах ажил газар шороо тэгшлэх гүйцэтгэгч шалгаруулах шатанд хэрэгжиж байна. | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 21 дүгээр хорооны Буянт-Ухаа 2 хороолол иргэд олон нийтэд зориулсан тохижилт, ногоон байгууламж бүхий бичил цэцэрлэгийн ажил хэрэгжиж байна. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 1 дүгээр хороо, 9, 25 дугаар байрны гадна хүүхдийн тоглоомын талбай байгуулах, хуучин хөл бөмбөгийн талбайг сэргээн засварлах ажил он дамжин хэрэгжиж ашиглалтад орсон. | |
| 10 | Шинэ Хан-Уул цэцэрлэгт хүрээлэнгийн баруун талд "Өглөөний гудамж" байгуулж, Хан-Уул өндөрлөг орчмыг тохижуулна. | 980.0 /ДТХО/ | Өглөөний гудамж байгуулагдсан эсэх, ажлын явц, хувь | - | Өглөөний гудамж байгуулагдсан байна. | Дүүргийн 1 дүгээр хороо Шинэ Хан-Уул цэцэрлэгт хүрээлэнгийн баруун талд "Өглөөний гудамж" байгуулах ажлын зураг төсөл, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажил 30 хувийн гүйцэтгэлтэй байна. | 60% |
| **Зорилт 1.8** Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлнэ. /ЗГҮАХ 6.2.6/ | | - | Санал асуулга зохион байгуулсан эсэх | Цахим санал асуулга 63 хувьтай явагдсан. | Цахим санал асуулга зохион байгуулсан байна. | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх төсөл арга хэмжээнд иргэд олон нийтээс цахимаар санал авах ажлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулсан.Санал асуулга явагдаж буй хугацаанд хороодын зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарт шинээр аппликейшин ашиглалтад орсонтой холбоотойгоор Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгын явцын мэдээллийг танилцуулж, "e-mongolia", "Орон нутгийн хөгжлийн сан" аппликейшинээр санал өгөх заавар зөвлөмж өгч ажилласан. Мөн иргэдийг идэвхтэй хамруулж, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хороо тус бүрд 140 ширхэг тараах материал хүргүүлж, "Орон нутгийн хөгжлийн сангийн цахим санал асуулга" удирдамж батлан зохион байгуулагч, хэсгийн ахлагчдын дунд уралдаан зарласан. Хан-Уул дүүргийн хэмжээнд 18-аас дээш насны 89,836 иргэн хамрагдахаас 28,076 иргэн санал өгч, 30.3 хувьтай хамрагдсан байна. | 100% |
| 11 | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд | ҮА-ны зардлаар | Цахим санал асуулга зохион | Цахим санал асуулга 63 | Цахим санал асуулга зохион | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх төсөл арга хэмжээнд иргэд олон нийтээс цахимаар санал авах ажлын 2022 оны 04 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс авах санал асуулгыг цахим аппликейшн ашиглан зохион байгуулна. | | байгуулсан эсэх | хувьтай явагдсан. | байгуулсан байна. | дүгээр сарын 15-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Санал асуулга явагдаж буй хугацаанд хороодын зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарт шинээр аппликейшин ашиглалтад орсонтой холбоотойгоор Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгын явцын мэдээллийг танилцуулж, "e-mongolia", "Орон нутгийн хөгжлийн сан" аппликейшинээр санал өгөх заавар зөвлөмж өгч ажилласан. Мөн иргэдийг идэвхтэй хамруулж, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хороо тус бүрд 140 ширхэг тараах материал хүргүүлж, "Орон нутгийн хөгжлийн сангийн цахим санал асуулга" удирдамж батлан зохион байгуулагч, хэсгийн ахлагчдын дунд уралдаан зарласан. Хан-Уул дүүргийн хэмжээнд 18-аас дээш насны 89,836 иргэн хамрагдахаас 28,076 иргэн санал өгч, 30.3 хувьтай хамрагдсан байна.. | |
| **Зорилт 1.9** Гэр хорооллын айл өрхүүдийг стандартын шаардлага хангасан түлшээр хангаж, агаарын бохирдлыг бууруулна. /ЗГҮАХ 5.1.1/ | | - | Түлшний хэмжээ | 28590.4тонн түлш олгосон. | 20.000 тонноос доошгүй түлшээр хангасан байна. | 2021-2022 оны галлагааны улиралд дүүргийн гэр хорооллын 13 хорооны айл өрхүүдийг нийт 24,577.97 тн сайжруулсан шахмал түлшээр хангасан. | 100% |
| 12 | Гэр хорооллын айл өрхүүдийг стандартын шаардлага хангасан түлшээр хангах борлуулалтын цэг, хангамжийн баазуудыг байгуулж, хэвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллана. | - | Хангамжийн бааз, борлуулалтын цэгийн тоо | 1 хангамжийн бааз, 53 борлуулалтын цэг байгуулсан. | 1 хангамжийн бааз, 50-аас доошгүй борлуулалтын цэг байгуулна. | Дүүргийн хэмжээнд 2021-2022 оны галлагааны улиралд сайжруулсан шахмал түлшний борлуулалтын 53 цэг, 1 савлагааны хангамжийн бааз үйл ажиллагаа явуулсан. Тус цэгүүдийн түлшний борлуулалт, тээвэрлэлтэд өдөрт 2 удаагийн давтамжтай хяналт тавьж ажилласан. | 100% |
| 13 | Төрийн өмчийн халаалтын зуухнуудыг үе шаттайгаар | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 1 хүртэлх халаалтын зуухыг төвлөрсөн | Дүүргийн 6 дугаар хороонд байрлах "Хоёулаа миний хүү" ХХК-ны зуухнаас халаалт авдаг 6 дугаар хорооны байр, Цагдаагийн 2-р хэлтэс, Дүүргийн нэгдсэн амбулатори, Шуудан холбоо | 30% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төвлөрсөн дулаанд холбоно. | | | | дулаанд холбоно. | зэрэг байгууллагууд "Цэвэр агаар" төслийн санхүүжилтээр 2022 онд төвлөрсөн халаалтад шилжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажил хангагдаж байна. | |
| 14 | Дүүргийн хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулж, цахим бүртгэлийн санд оруулна. | - | Тооллого зохион байгуулж, цахим бүртгэлийн санд оруулсан эсэх | Тооллогыг 1 удаа зохион байгуулж, цахим бүртгэлийн санд оруулсан. | Мэдээллийн санг шинэчилсэн байна. | Агаар бохирдуулж байгаа эх үүсвэрийн тооллогыг дүүргийн гэр хорооллын 13 хорооны айл өрхөд явуулж, бүртгэл, мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлж ажилласан. Тооллогод ердийн зуухтай гэрт амьдардаг 4420 өрх, ердийн зуухтай байшинд амьдардаг 5688 өрх, сайжруулсан зуухтай гэрт амьдардаг 2848 өрх, сайжруулсан зуухтай байшинд амьдардаг 3877 айл өрхийн мэдээллийг шинэчлэн бүртгэсэн. Мөн мэдээллийн санд гэр хорооллын нийт 17090 өрхийн мэдээлэл, 16-100 кВт хүчин чадалтай нам даралтын зуухтай 116 аж ахуйн нэгж байгууллага, 100 кВт-аас дээш хүчин чадалтай 18 уурын халаалтын зуухтай аж ахуйн нэгж байгууллагуудын мэдээллийг шинэчлэн оруулсан. | 100% |
| 15 | Гэр хорооллын айл өрхүүдийг угаартах эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж, мэдээлэл хүргэх ажил зохион байгуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээ, мэдээлэл хүргэсэн айл өрхийн тоо | 3, 4, 9, 10 дугаар сард угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээллийг 18000 айл өрхөд хүргэх ажлыг зохион байгуулсан. | Галлагааны улиралд угаарын хийн хордлогоос сэргийлэх зөвлөмж мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж, зөвлөмж мэдээллийг 18000 өрхөд хүргэнэ. | 2021-2022 оны галлагааны улиралд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх тухай гарын авлага 15000 ширхгийг гэр хорооллын айл өрхөд тарааж, 2 төрлийн зураг бүхий 975 ширхэг плакатыг хүн ам ихээр цуглардаг худалдааны төв, халуун усны байр, хорооны байрны гадна талд байршуулан нааж иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулсан. | 100% |
| 16 | Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүдийн 100 кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын уурын зуухнуудад | - | Зохион байгуулсан хяналт шалгалтын тоо | 18 халаалтын зууханд хяналт шалгалт зохион байгуулсан. | 18 тусгай зөвшөөрөлтэй уурын зуухнуудад хяналт шалгалт хийнэ. | Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг 16-100 кВт-н хүчин чадалтай нам даралтын зуухтай 116 аж ахуйн нэгж байгууллага, 100 кВт-аас дээш хүчин чадалтай 26 аж ахуйн нэгж байгууллага, 100 кВт-аас дээш хүчин чадалтай 18 аж ахуйн нэгж байгууллагын уурын зуухыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт шалгалтыг зохион байгуулах. | | | | | "Магадлан итгэмжлэх" хяналт шалгалтад хамруулсан. | |
| 17 | Агаарын бохирдлын эх үүсвэр, хор уршиг, дэвшилтэт техник, технологи, ногоон амьдралын хэв маягийн талаар танин мэдүүлэх, зөв дадал хэвшилд сургах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 2 арга хэмжээ зохион байгуулсан. | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулна. | Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр олон нийтийн оролцоог хамарсан 3 арга хэмжээг зохион байгуулж, 15 постер, 3 шторк бэлтгэн олон нийтэд хүргэсэн. | 100% |
| **Зорилт 1.10** Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлж, хөрсний бохирдлыг бууруулна. /ЗГҮАХ 5.1.4/ | | Улсын төсөв | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо | 850 ариун цэврийн байгууламж нэвтрүүлсэн. | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг 1000-д хүргэнэ | Дүүргийн гэр хорооллын хороодод барьсан стандартын бус нүхэн жорлонг 2021 онд 13855 байсныг 2022 оны 06 сарын байдлаар 10475 болгож 3380-аар бууруулж ажилласан. | 100% |
| 18 | Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлж, хөрсний бохирдлыг бууруулна. | Улсын төсөв | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо | 850 ариун цэврийн байгууламж нэвтрүүлсэн. | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг 1000-д хүргэнэ | Дүүргийн гэр хорооллын хороодод барьсан стандартын бус нүхэн жорлонг 2021 онд 13855 байсныг 2022 оны 06 сарын байдлаар 10475 болгож 3380-аар бууруулж ажилласан. Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо 1307 болж нэмэгдсэн. | 100% |
| **Зорилт 1.11** "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга | | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 5-аас дээш арга хэмжээ зохион байгуулна. | Хан-Уул дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвүүд болон Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилтнуудаас бүрдсэн тандалт, шуурхай хариу арга хэмжээний 3 баг 24 цагаар ажиллаж, дүүргийн хэмжээнд ковидын дуудлага, үзлэг бүрийг цаг алдалгүй 100% хүлээн авч ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| хэмжээг хэрэгжүүлнэ./ЗГҮАХ1.1/ | | | | | | Түргэвчилсэн болон пср шинжилгээний 22, дархлаажуулалтын 11 явуулын түр цэгийг ажиллуулсан. Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын 1-р тунд 392, 2-р тунд 1297, 3-р тунд 9481, 4-р тунд 10399, 5-р тунд 3 хүнийг хамруулсан. 2022 оны эхний 5 сарын өссөн дүнгээр 1-р тунд 178147 буюу 121,0%, 2-р тунд 177493 буюу 120,5%, 3-р тунд 68619 буюу 46,6% хүнийг хамруулсан байна. Үүнийг нийслэлийн хүн амын тоонд харьцуулбал: 1-р тунд 16.03%, 2-р тунд 16.0%, 3-р тунд 6.2% нь дархлаажуулалтад хамрагдсан байна. | |
| 19 | "Ковид-19" цар тахлын үед дүүргийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллага болон тусгаарлан ажиглах байраар ашиглах боломжтой объектын судалгаа, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн судалгааг тогтмол гаргаж хянана. | - | Шинэчилсэн судалгааны тоо | 7 төрлийн судалгаа гаргасан. | | Коронавируст халдварын 28038 тохиолдол батлагдаж, Туул тосгоны 80 ортой түр эмнэлэгт 230, Нэгдсэн эмнэлгийн 150 ортой "Ковид-21" тасагт 761, бусад эмнэлэгт 2371, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмчийн хяналтад 24676 иргэн эмчлүүлсэн. "Био салбар" эмнэлэгт ковидын 40 ортой түр эмнэлгийн бэлэн байдлыг хангаж, эмнэлгүүд 2 сарын нөөц бүрдүүлэн ажилласан. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн эмнэлэг, эмийн сангийн судалгааг шинэчлэн гаргасан.<br>Судалгаагаар улсын эмнэлэг-4, хувийн эмнэлэг-105, эмнэлгийн нийт орны тоо-1990, нийт их эмчийн тоо-440, эмийн сан-150 бүртгэгдсэн. | 100% |
| **Зорилт 1.12**<br>"Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээг хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ 2.1.1.7/ | | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулна. | "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, өсвөр насны эрэгтэй хүүхдийн нөхөн үржихүй, хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэнд, хоол тэжээл, осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр Эрүүл мэндийн төв болон өрхийн эрүүл мэндийн төвүүд цахим хуудсаар дамжуулан мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна. Тус дүүргийн ерөнхий боловсролын 15 сургуулийн 2500 гаруй хөвгүүдэд танхим болон цахимаар сургалт зохион байгуулсан. Өсвөр насны хөвгүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг хэрэгжүүлж, нийт 636 хөвгүүдэд утсаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. 2022 оны эхний ээлжийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэрэг татлагаар 4478 цэргийн насны залуучууд 12 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдсанаас 790 буюу 18% нь өвчтэй илэрч, 8 төрлийн шинжилгээнд 350 залуучуудыг хамруулсан. Гэр оронгүй, архины хамааралтай иргэдийг түр хоноглох үйлчилгээнд хамруулдаг "Хаган богда" төрийн бус байгууллагад байрлаж буй 30 иргэнийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. | |
| 20 | Дүүргийн Эрүүл мэндийн төвд Эрэгтэйчүүдийн кабинет байгуулна. | - | Кабинет байгуулсан эсэх, гүйцэтгэлийн хувь | НЭМГ-ын 2022 оны төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлсэн. | 8-аас дээш арга хэмжээ зохион байгуулна. | Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тасагт "Эрэгтэйчүүдийн кабинет"-ын үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөж, Нийслэлийн Эрүүл мэндийн газарт кабинет байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг хүргүүлсэн. "Эрэгтэйчүүдийн кабинет"-ыг байгуулахтай холбогдуулан эмч, сувилагч нарыг чадавхжуулах сургалтад хамруулж, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргасан. | 30% |
| **Зорилт 1.13** Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ. /ЗГҮАХ 2.2.1/ | | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 8-аас дээш арга хэмжээ зохион байгуулна. | Иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр дараах спортын арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:<br>1. "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аянд спортын заал-7, фитнес-1, гадаа талбай-2, клуб-1, чийрэгжүүлэх танхим-4, урлаг заал-2, нийт 16 байршилд 5-74 насны 28418 иргэн;<br>2. "Улаанбаатар марафон-2022" цомыг 2022 оны 4 дүгээр сарын 08-аас 5 дугаар сарын 20-ыг хүртэл 106 байгууллагаар аялуулж, цом аялах хугацаанд албан хаагчдын дунд спортын 189 уралдаан, тэмцээнд 6097 албан хаагч;<br>3. 2022 оны 5 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан "Улаанбаатар Марафон-2022" олон улсын гүйлт, "Авто машингүй өдөр"-ийн өдөрлөгт 1400 тамирчин, 150 гаруй төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллагын 1614 ажилтан, албан хаагч, урлаг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | спорт, олон нийтийн арга хэмжээнд 1200 гаруй иргэн, нийт 4200 гаруй иргэн;<br>4. Хан-Уул дүүргийн аварга шалгаруулах “Гимнастрада” уралдаант үзлэгт 20 байгууллагын 400 гаруй албан хаагч, иргэд;<br>5. “Хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох" арга хэмжээнд 33 байгууллагын 3830 ажилтан, албан хаагч, иргэд;<br>6. "Хамтдаа алхаад эрүүлжье" 10 удаагийн явган алхалтад 800 гаруй албан хаагч, иргэд;<br>Дүүргийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн хурлаас дүүргийн нутаг дэвсгэрийн сургууль, орон сууц, хотхоны гаднах биеийн тамир, спортын талбайг 6:00-20:00 цагийн хооронд нээлттэй байлгаж, иргэдэд биеийн тамир, спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх үүрэг чиглэлийг өгсөн. | |
| 21 | "Иргэдийн спортын Их наадам"-ыг спортын 8 төрлөөр зохион байгуулна. | - | Хамрагдсан иргэдийн тоо | 860 иргэнийг хамруулсан. | Спортын 8 төрөлд иргэн хамруулна. | /Хугацаа болоогүй./ | - |
| **Зорилт 1.14** Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 3.3.3/ | | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 арга хэмжээ зохион байгуулсан. | 5-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулна. | Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2 арга хэмжээ зохион байгуулж, 459,1 тн мах худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, махны чанар аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан. | 90% |
| 22 | Иргэдийн хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мах, ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулж, хяналт тавина. | 3000.0 | Зохион байгуулсан арга хэмжээ, хяналт шалгалтын тоо | 3 арга хэмжээ зохион байгуулж, хяналт тавина ажилласан. | 5-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж, хяналт тавьж ажиллана. | Дүүргийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор:<br>• Нөөцийн махны худалдааг 50 дэлгүүрээр 135,6 тонн мах<br>Өргөтгөсөн худалдааг 2 дугаар улирлын амралтын өдрүүдэд давхардсан тоогоор 39 байршилд 323,5 тн махыг худалдаалах ажлыг зохион байгуулж, дүүрэг дэх Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс, хороодтой хамтран махны чанар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аюулгүй байдалд хяналт тавьж, иргэдийн гомдол санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж ажилласан. Дүүргийн хэмжээнд нийт 459.1 тонн нөөцийн мах худалдан борлуулж, хүн амын махны хангамжийг нэмэгдүүлж ажилласан. | |
| **Зорилт 1.15** Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ 3.3.13/ | | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 арга хэмжээ зохион байгуулсан. | Үйлдвэрлэл эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна. | Хан-Уул дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж "Бойжуулах төв"-ийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд шаардагдах төсөвт өртөг бүхий төслийг боловсруулж Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. | 100% |
| 23 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид чиглэсэн худалдааны 1-2 цэг байгуулж, борлуулалтыг дэмжин ажиллана. | 35 сая | Байгуулсан цэг, дэмжин ажилласан үйлдвэрлэл эрхлэгчийн тоо | 3 арга хэмжээ зохион байгуулсан. | 1-2 цэг байгуулж, 20-30 үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжсэн байна. | "Хан-Уулд үйлдвэрлэв" борлуулалтын төвийг хүн амын нягтаршил сайн, ашигтай талбайд нээхээр дүүргийн 10 гаруй томоохон худалдааны төвийн судалгааг гаргасан. Уг судалгаагаар байршил, м2 тутмын үнэ, иргэдийн нягтаршил зэргийг харгалзан үзэж дүүргийн 4 дүгээр хороонд байрлах "Фүүд сити" худалдааны төвийг сонгосон. Борлуулалтын төвийн үйл ажиллагааг нээх санхүүжилтийг "Эко Ногоон дүүрэг" дэд хөтөлбөрөөс гаргуулах саналтайгаар "Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих төсөл"-ийг боловсруулан ажлын хэсэг, Засаг даргын зөвлөлийн хурлаар танилцуулсан. Төрийн Хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд уг төслийн хэрэгжих хугацаа хойшилсон. | 70% |
| **ХОЁР. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **Зорилт 2.1** Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, | | | Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ, хамрагдсан албан хаагчийн тоо | 2 удаагийн сургалтад 11 албан хаагч хамруулсан. | Авлигаас урьдчилан сэргийлэх сургалтад хамруулж,төлөвлөгөөг 100% хэрэгжүүлнэ. | Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 4 төрлийн тв шторк, видео график, теле зохиомжийг дүүргийн www.khanuul.mn цахим хуудасны авлигын эсрэг үйл ажиллагааны ил тод буланд байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| шуурхай, нээлттэй байдлыг хангана. /ҮХ 2.1/ | | | | | | | |
| 24 | Авлигын эсрэг 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, иргэд, албан хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтад хамруулж, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан сургалт,арга хэмжээ хамрагдсан албан хаагч, иргэдийн тоо | 2 удаагийн сургалтад 11 албан хаагч хамруулсан. | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө 90-100 хувьтай хэрэгжсэн байна. | Авлига, хүнд суртлыг таслан зогсоох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувьтай байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга нар мөн орон нутгийн өмчит байгууллагын удирдлагууд нийт 31 албан тушаалтныг Авлигын эсрэг нийслэлийн зөвлөгөөнд оролцуулсан. Төрийн байгууллагын албан хаагчдыг авлигын эсрэг хууль тогтоомж, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх сургалтад 4 албан хаагчийг хамруулсан. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Шударга байдлын үнэлгээ 2022" судалгаанд байгууллагын 30 албан хаагч болон Засаг даргын Тамгын газартай хамтран ажилладаг 20 байгууллага, албан хаагчаас шинжээчийн судалгаа авч холбогдох байгууллагад хүргүүлсэн. | 100% |
| **Зорилт 2.2** "Хүнсний ногоо" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, өрхийн тариалан эрхлэгч болон хүнсний ногооны төрөлжсөн аж ахуйн нэгж, хоршоог дэмжих замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 арга хэмжээ зохион байгуулсан. | Хүнсний ногооны үйлдвэрлэл нэмэгдсэн байна. | Хүнсний ногооны тариалалтыг дэмжих ажлын хүрээнд хүнсний ногоо, хүлэмжийн таримлын үр хөнгөлөлттэй авах ногоочдын хүсэлтийн дагуу 250 өрхөд хүнсний ногооны үрийг үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр олгож, тариалалтыг дэмжин ажилласан. | 100% |
| 25 | Өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжиж ажиллана. | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 арга хэмжээ зохион байгуулсан | Өрхийн тариалалт нэмэгдсэн байна. | Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр:<br>• Дүүргийн 10, 12, 13, 14 дүгээр хорооны 250 өрхөд 2.2 сая төгрөгийн үнэ бүхий хүнсний ногооны үрийг олгож, тариалалтыг дэмжин ажилласан. Үүнд:<br>• Хүнсний ногооны борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 3 удаагийн үзэсгэлэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | худалдаанд хүлэмжийн тариалан эрхлэгч 10 иргэн, аж ахуйн нэгжийг оролцуулж, эрт ургацын хүнсний ногоог олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан.<br>• 10 дугаар хороо Морингийн даваанЫ 15 өрхөд "Жишиг хүлэмжийн төсөл"-ийг хэрэгжүүлсэн.<br>Засгийн газраас хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих" 3 хувийн хүүтэй зээлд хамрагдах хүсэлтэй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, хүлэмж, үр тариа, тос тэжээлийн таримлын тариалалтын үйлдвэрлэл эрхэлдэг 477 иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж, ХХААХҮЯ-д хүргүүлсэн. | |
| **Зорилт 2.3** Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт тооцох, тайлагнах ажлыг зохион байгуулна. | | - | Хэрэгжилтийг хугацаанд нь хүргүүлсэн эсэх | Хөтөлбөрийн биелэлтийг авч, нэгтгэсэн. | Хөтөлбөрийн биелэлтийг авч, нэгтгэн НЗДТГ-т хүргүүлнэ. | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийг 2022.12.20-ны өдөр НЗДТГ-т хүргүүлнэ. Хугацаа болоогүй. | - |
| 26 | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулж, холбогдох хэлтэс албадаас тайланг авч нэгтгэн НЗДТГ-т хүргүүлнэ. | - | Хэрэгжилтийг хугацаанд нь хүргүүлсэн эсэх | Хөтөлбөрийн биелэлтийг авч, нэгтгэсэн. | Хөтөлбөрийн биелэлтийг авч, нэгтгэн НЗДТГ-т хүргүүлнэ. | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийг 2022.12.20-ны өдөр НЗДТГ-т хүргүүлнэ. Хугацаа болоогүй. | - |
| **ГУРАВ. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **Зорилт 3.1** Хүүхдийн зуслан, бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тоог нэмэгдүүлж, иргэдийн эрүүл аюулгүй хөгжлийн орчныг бүрдүүлэх бодлого баримтална. /НЗДҮАХ 5.1.1.1/ | | - | Зураг төсөв хийлгэж, санал уламжилсан эсэх. | 1 байршилд зуслангийн архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан. | 2 байршилд зуслангийн зураг төсвийг хийлгэж, төсөвт санал уламжилна. | Дүүргийн 13 дугаар хороонд байрлах 32 дугаар сургуулийн сургалтын талбайд англи хэлний вакумжуулсан сургалттай хүүхдийн зуслангийн зураг төсөл, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Нью товер" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 60 хувьтай.<br>Дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 13.5 га газарт залуу иргэд гэр бүлээрээ амрах зориулалт бүхий "Эко зуслан"-ийн зураг төсвийн ажлын зөвлөх үйлчилгээний тендерийг 2022 оны 06 дугаар сарын 06-нд нээсэн. Нэг аж ахуйн нэгж байгууллага материал ирүүлсэн. Тендерийн баримт бичигт үнэлгээ хийгдэж байна. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | 13 дугаар хороонд байрлах 32 дугаар сургуулийн сургалтын талбайд англи хэлний вакуумжуулсан сургалттай хүүхдийн зуслан, 14 дүгээр хороонд залуу гэр бүлд зориулсан эко зуслангийн зураг төсвийг хийлгэнэ. | 100.0 /ДТХО/ | Зураг төсөв хийлгэж, санал уламжилсан эсэх. | 1 байршилд зуслангийн архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан. | 2 байршилд зуслангийн зураг төсвийг хийлгэж, төсөвт санал уламжилна. | Дүүргийн 13 дугаар хороонд байрлах 32 дугаар сургуулийн сургалтын талбайд англи хэлний вакумжуулсан сургалттай хүүхдийн зуслангийн зураг төсөл, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Нью товер" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 60 хувьтай. Дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 13.5 га газарт залуу иргэд гэр бүлээрээ амрах зориулалт бүхий "Эко зуслан"-ийн зураг төсвийн ажлын зөвлөх үйлчилгээний тендерийг 2022 оны 06 дугаар сарын 06-нд нээсэн. Нэг аж ахуйн нэгж байгууллага материал ирүүлсэн. Тендерийн баримт бичигт үнэлгээ хийгдэж байна. | 70% |
| 105 | Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг тулган баталгаажуулж, хуулийн хугацаанд Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэх. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн тоо, хувь | 2021 оны төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг хуулийн хугацаанд хүргүүлсэн. 205 байгууллага Shilendans.gov.mn сайтад | Мэдээнд цэвэрлэх бичилт хийгдэн, нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээг хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. Шилэн | Дүүргийн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд орон нутгийн байгууллагууд 16, төрийн өмчийн цэцэрлэг 30, сургууль 21, нийт 67 байгууллагын мэдээ нэгтгэгдэн, орон нутгийн төсвийн цэцэрлэг, сургууль болон орон нутгийн байгууллагуудын 01-05 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг Сангийн яамны програмтай тулган баталгаажуулан ажилласан. Төсөвт байгууллагуудын дансанд орсон нийгмийн даатгалын байгууллагаас орсон орлого, нэр данс зөрүү орлого, байгууллагын өөрийн орлого зэргийг 01-06 дугаар саруудад 77 удаагийн бичилтээр Сангийн яамны санхүүгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 100% байршуулсан | дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | удирдлагын системд нэг бүрчлэн шивж оруулан, орлого цэвэрлэх бичилт хийгдсэн байна. | |
| 106 | Аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд И-Баланс системд цахим хэлбэрээр хүлээн авч, хянан баталгаажуулах, бүртгэлийн алдааг залруулах, шинээр байгуулагдаж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад заавар зөвлөгөө өгөх. | - | Хууль, тогтоомжийн заалтыг хангасан байх, байгууллага, иргэний тоо, хувь | 2020 оны жилийн эцсийн байдлаар 11,518 тайлан буюу 81.1%-ийг хүлээн авсан. 2021 оны хагас жилийн байдлаар 7840 тайлан буюу 53.2%-ийг хүлээн авсан. | 2022 оны эцсийн тайлан санхүүгийн тайлан 15350 ААНБ-удын тайлан баталгаажсан , 120 ААНБ-ын тайлангийн залруулга хийн, 2400 аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд арга зүйн зөвлөгөө өгсөн байна. | Нэгтгэлийн программд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан өгвөл зохих нийт 16030 аж ахуйн нэгж, байгууллагаас 12972 тайлан буюу 80,9%-ийг цахим системээр ирүүлсэн байна. Үүнээс 11355 байгууллага буюу 70,8%-ийг баталгаажуулж, 1617 байгууллагын алдаатай болон аудитын байгууллагын нэрийн баталгаажуулалт хийгдээгүй тайланг буцаасан. 2490 аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд арга зүйн зөвлөгөө өгөн ажилласан. | 100% |
| **ТАВ. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **Зорилт 5.1** Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай хүргэнэ. | | | | | | | |
| 10 | Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангаж албан хаагчдын зэрэг дэвийг шинэчлэн, холбогдох нэмэгдлийг тухай бүр олгоно. | - | Зэрэг дэв, хугацаа, илүү цагийн нэмэгдэл олгосон албан хаагчийн тоо | Зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон-14, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр болон ахиулан олгосон-39, цалингийн шатлалыг ахиулсан-53 албан хаагч. | 5-аас доошгүй албан хаагчийн зэрэг дэвийг шинэчлэн, нэмэгдлийг тухай бүр олгоно. | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын албан хаагчдын төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг боловсруулан Засаг даргын Тамгын газрын даргын 2022.02.21-ний өдрийн 04/226 дугаартай албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2022.05.12-ны өдрийн А/641 дүгээр захирамжаар нийт 31 төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгосон.<br>Үүнээс Засаг даргын Тамгын газар болон хорооны 10, дэргэдэх хэлтэс, албаны 4 албан хаагчийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зэрэг дэвийг ахиулан олгосон бөгөөд Засаг даргын Тамгын газар болон хорооны нийт 17 албан хаагчид төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг шинээр олгосон.<br>Монгол Улсын Засгийн газраас төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны Б/78 дугаар тушаалаар Тамгын газрын төрийн захиргааны 44 албан хаагчийн, хорооны 52 албан хаагчийн ангилал, зэрэглэлийг, төрийн үйлчилгээний 11 албан хаагчийн цалингийн хэмжээг тус тус шинэчлэн батлуулж, Төрийн албаны зөвлөлийн "Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо" системд бүртгэлийг шинэчилсэн. | |
| 108 | Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшил, тогтвор суурьшилтай ажилласан байдал, амьдралын нөхцөлийг харгалзан албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, ЗДТГ-ын Дотоод журмын дагуу буцалтгүй тусламж олгоно. | - | Нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлж, буцалтгүй тусламжид хамруулсан албан хаагчдын тоо | 36 албан хаагчийн нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлж, Дотоод журмын дагуу буцалтгүй мөнгөн тусламжид нийт 36,952,262 төгрөг зарцуулсан. | 20-оос доошгүй албан хаагчид дэмжлэг, тусламж үзүүлсэн байна. | Тайлант хугацаанд ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшил, тогтвор суурьшилтай ажилласан байдал, амьдралын нөхцөлийг харгалзан 18 албан хаагчийн нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлсэн.<br>Засаг даргын Тамгын газрын дотоод журмын дагуу 17 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.<br>Засаг даргын Тамгын газраас өндөр насны тэтгэвэрт гарсан 67 ахмад настанд 2022 оны "Сар шинийн баяр"-ыг тохиолдуулан нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлсэн. | 100% |
| 109 | Засаг даргын Тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг тус тус нэгтгэн боловсруулж тайлагнана. | - | Төлөвлөсөн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | 67 зорилтын хүрээнд 146 арга хэмжээг төлөвлөн 93.2%-тай хэрэгжсэн. | Төлөвлөсөн арга хэмжээ 90-100 хувьтай хэрэгжсэн байна. | Төсвийн Шууд захирагчийн "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгах саналыг хэлтэс, тасгуудаас хүлээн авч нэгтгэн 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр батлуулсан.<br>Тус төлөвлөгөө нь нийт 6 бүлгээс бүрдэж байгаа бөгөөд нэгдүгээр бүлэг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 15 зорилт, 23 арга хэмжээ, хоёрдугаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүлэг Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээнд 3 зорилт, 3 арга хэмжээ, гуравдугаар бүлэг Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээнд 11 зорилт, 16 арга хэмжээ, дөрөвдүгээр бүлэг дүүргийн Засаг даргын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилт арга хэмжээнд 35 зорилт, 64 арга хэмжээ, тавдугаар бүлэг Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд 1 зорилт, 32 арга хэмжээ, зургаадугаар бүлэг Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд 1 зорилт, 16 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2022 оны эхний хагас жилийн байдлаар 66 зорилт .... хувьтай, 154 арга хэмжээ .... хувьтай тус тус хэрэгжсэн. | |
| 110 | Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн боловсруулж батлуулан, НЗДТГ-т тайлант хугацаанд хүргүүлнэ. | - | Тайлагнасан байдал, үр дүн | Холбогдох хугацаанд нь НЗДТГ-т хүргүүлсэн. | Үйл ажиллагаа ил тод, бодитой үр дүнд хүрч, холбогдох албан тушаалтад тайлагнасан байна. | Засаг даргын Тамгын газрын 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг нийслэлийн Засаг даргын 2017 оны 335 дугаар захирамжийн хавсралтад заасан журмын дагуу нэгтгэн боловсруулж Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 26–ны өдрийн 04/..... дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. | 100% |
| 111 | Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг батлуулж, үр дүнг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулна. | - | Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж, үнэлүүлсэн албан хаагчдын тоо | ЗДТГ болон хороодын нийт 117 албан хаагчдын үр дүнг үнэлж, холбогдох урамшууллыг журмын дагуу олгосон. | Хэрэгжүүлэх ажлууд бодитой үр дүнд хүрэхүйц төлөвлөгдөн, үнэлэгдсэн байна. | Засгийн газрын 2020 оны 217, 218 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах хүрээнд албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх "Үнэлгээний баг"-ийн бүрэлдэхүүнийг ЗДТГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан. Засаг даргын Тамгын газрын 11 хэлтэс, албадын ...., хороодын 49 нийт .... албан хаагчийн 2022 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн нэгжийн даргын үнэлгээг, тайлангийн хамт 06 дугаар сарын 15-ны өдөр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүлээн авч .......-ний өдөр хуралдан, үнэлгээг бодитой дүгнэсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч баталгаажуулан, холбогдох урамшууллыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны ... сарын ....-ны өдрийн ...... тушаалаар холбогдох урамшууллыг олгуулсан. | |
| 112 | Засаг даргын Тамгын газрын тайлангийн хурлыг зохион байгуулна. | - | Хурал зохион байгуулагдсан эсэх, ажлын үр дүн | Тайлангийн хурлыг 2021 оны 12 сарын 31-нд зохион байгуулсан. | Тайлангийн хурлыг зохион байгуулж, ажлын үр дүнгээ тайлагнасан байна. | Хугацаа болоогүй, 12 дугаар сард зохион байгуулна. | - |
| 113 | Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь тайлагнана. | - | Өгөгдсөн үүрэг даалгаврын тоо хэрэгжилтийн хувь | 18 удаа зохион байгуулж, 157 үүрэг даалгавар өгөгдөн 90.3 %-тай хэрэгжсэн. | Биелэлтийг тухай бүр гарган хугацаанд нь тайлагнана. | Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар 8 удаа зохион байгуулж, 76 үүрэг даалгавар өгөгдөн 80.3 хувьтай хэрэгжсэн. | 100% |
| 114 | Дээд газраас ирсэн тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэн, хугацаанд нь тайлагнана. | - | Хяналтад авсан тогтоол шийдвэрийн заалтын тоо, үр дүн, тайлан | 15 тогтоол шийдвэрийн 30 заалтын биелэлт 94.2%-тай хэрэгжсэн. | Улирал тутам тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн, хугацаанд нь тайлагнана. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын 2022 оны 01 дүгээр улирлын байдлаар тайлагнах 4 тогтоолын холбогдох 12 заалтыг хяналтад авч, биелэлтийг нэгтгэн, Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулсан. /Биелэлт-45%/ Мөн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2022 оны 01 дүгээр улирлын байдлаар тайлагнах 4 тогтоолын биелэлтийг нэгтгэн 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 04/610 дугаар албан бичгээр хүргүүлсэн. /Биелэлт-80%/<br>Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны эхний хагас жилд тайлагнах 20 тогтоол шийдвэрийн холбогдох 60 заалтыг хяналтад авч, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу биелэлтийг Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг болон Засаг даргын дэргэдэх 29 хэлтэс, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албадаас авч нэгтгэж байна. Тайлагнах хугацаа болоогүй. | |
| 115 | Нийслэл, дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь тайлагнах, дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг тухай бүр зохион байгуулна. | - | Шуурхай зөвлөгөөний тоо, үүрэг даалгаврын биелэлтийн хувь | Үүрэг даалгавар 89%-тай хэрэгжсэн. | Биелэлтийг тухай бүр холбогдох албан тушаалтад танилцуулж, хугацаанд нь тайлагнасан байна. | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 13 удаа зохион байгуулагдан, нийт 112 үүрэг даалгавар өгөгдөж, 87.4%-тай хэрэгжсэн. Шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг холбогдох хэлтэс, албадаас авч нэгтгэн батлуулж, хугацаанд нь тайлагнан ажиллаж байна. Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар 20 удаа зохион байгуулан, нийт 53 үүрэг даалгавар өгөгдөж, 91%-тай хэрэгжсэн. | 100% |
| 116 | Дүүрэгт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгнө. | - | Хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тоо, үр дүн, тайлан | 5 төрлийн бодлогын баримт бичигт хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн. | Бодлогын баримт бичгүүдэд хугацаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байна. | Хугацаа болоогүй. | - |
| 117 | Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод хяналтыг тавих замаар үүрэг хариуцлагыг дээшлүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. | - | Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тоо, үр дүн | Хяналт-шинжилгээ үнэлгээг 1 удаа зохион байгуулж, үр дүнг тайлагнасан. | 1-ээс доошгүй удаа хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ. | Хугацаа болоогүй. | - |
| 118 | Хороодын хэсгийн ахлагч нарын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулна. | 5.0 | Зохион байгуулсан эсэх, үр дүн | Зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, 210 хэсгийн | Арга хэмжээг зохион байгуулж, холбогдох албан | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ахлагчийг хамруулсан. | тушаалтад тайлагнасан байна. | тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам"-ыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтод түвшинд хүргэхээр зорин ажиллаж байна.<br><br>Дүүргийн хэмжээнд 1863 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг 06 хоног, 20 цаг, 35 минутад шийдвэрлэсэн.<br>Бичгээр - 933<br>Утсаар /1800-1200/ - 203<br>Утсаар /11-11 төв/ - 516<br>Тусгай дугаарын утас - 106<br>Хороод - 66<br>Eservice - 17<br>Цахимаар - 22<br>Засаг даргын Тамгын газар 378 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг 05 хоног, 16 цаг, 27 минутад шийдвэрлэх шийдвэрлэсэн байна. Нийслэлийн дундаж хугацаа 08 хоног 17 цаг 11 минутаас ихгүй хугацаанд шийдвэрлэсэн. Засаг даргын Тамгын газрын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн индекс 0,847 буюу В үнэлгээтэй, Нийслэлийн индекс 0,840 буюу В үнэлгээтэй байна. | |
| 119 | Хороодын Засаг дарга, зохион байгуулагч, хөгжлийн нийгмийн ажилтан нарын ажил мэргэжлийн ур чадварын тэмцээн зохион байгуулна. | 12.0 | Хамрагдсан хороодын тоо, албан хаагчдын тоо | Ур чадварын тэмцээн зохион байгуулагдааг үй. | Албан хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилсэн байна. | Удирдлагын шийдвэрээр хойшлогдсон. | - |
| 120 | Иргэдийн эрэлт, хүсэлт, өргөдөл, гомдлыг ERP "Өргөдөл гомдлын нэгдсэн систем" болон бусад арга хэрэгслээр хүлээн авч, шийдвэрлэлтийн | - | Дүүргийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн индекс, шийдвэрлэлтийн дундаж хоногоор | 2992 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг 08 хоног, 01 цаг, 14 минутад шийдвэрлэсэн. | Нийслэлийн түвшингээс доош хугацаанд шийдвэрлэж, хариу өгсөн байна. | Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан "Хан-Уул дүүргийн иргэдэд нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай журам"-ыг мөрдөн, ажиллаж байна. Журамд заасны дагуу хороодын Нийгмийн ажилтнаар мөнгөн тусламж хүссэн иргэдийн гэрээр очин судалгаа хийлгэж, нөхцөл байдлын үнэлгээг батлагдсан маягтын дагуу хийлгэсний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хариуг иргэнд шуурхай өгч ажиллана. | | | | | үндсэн дээр 2022 оны эхний хагас жилийн байдлаар дүүргийн Засаг даргын 2 удаагийн захирамжаар нийт 28 иргэнд 9,800,000 /есөн сая найман зуун мянга/ төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон. | |
| 121 | Засаг даргын иргэдтэй хийх уулзалтыг журмын дагуу зохион байгуулж, тэмдэглэл хөтлөн иргэдээс гарсан санал, хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллана. | - | Уулзалтад хамрагдсан иргэдийн тоо | Нийт 96 иргэний хүсэлтийг шийдвэрлэж, хариу өгсөн. | Тухай бүр иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулж, санал хүсэлтийг шийдвэрлэж ажиллана. | Тайлант хугацаанд байгууллага дээр цаасан болон цахим хэлбэрээр ирсэн нийт 2159 бичгийг бүртгэж удирдлагад шилжүүлж, байгууллагаас боловсруулсан 1032 албан бичгийг бүртгэж цаасан болон цахим хэлбэрээр илгээн MNS5140:2021 стандартыг мөрдөн ажилласан. | 100% |
| 122 | Иргэдэд нэг удаагийн буцалтгүй тусламж олгох ажлыг зохион байгуулна. | - | Буцалтгүй тусламжид хамрагдсан иргэдийн тоо | 92 иргэнд нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон. | Журмын дагуу иргэдэд буцалтгүй тусламж олгосон байна. | Хан-Уул дүүргийн Засаг даргын А захирамж 2022 оны эхний хагас жилийн байдлаар 1048, ЗДТГ-ын даргын тушаал 349 нийт 1397 захирамжлалын бланк хэвлэгдсэн байна. Нийт захирамжлалын болон зохион байгуулалт, мэдээлэл, лавлагааны 2029 албан бичгийн боловсруулалтад Монгол улсын MNS 5140:2021 стандартыг хэрэгжүүлж ажилласан. | 100% |
| 123 | Цахим баримт бичгийг хүлээн авах, шуурхай хянан шийдвэрлэх, цахим албан хэрэг хөтлөлтийн талаарх бодлого стандарт журмыг хэрэгжүүлж ажиллана. | - | Баримт бичгийн шийдвэрлэлтийн байдал | 2021 онд нийт 2384 бичиг боловсруулагдсан. | Баримт бичгийн шийдвэрлэлт зөрчилгүй, шуурхай шийдвэрлэсэн байна. | Тайлант хугацаанд байгууллага дээр цаасан болон цахим хэлбэрээр ирсэн нийт 2159 бичгийг бүртгэж удирдлагад шилжүүлж, байгууллагаас боловсруулсан 1032 албан бичгийг бүртгэж цаасан болон цахим хэлбэрээр илгээн MNS5140:2021 стандартыг мөрдөн ажилласан. | 100% |
| 124 | Албан хэрэг хөтлөх, бүрдүүлэх, эмх цэгцтэй хадгалах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, зохион байгуулах | - | Стандартыг мөрдүүлж ажилласан эсэх | MNS5140:2011 стандартыг мөрдөн ажилласан. | Баримт бичгүүд стандартын дагуу боловсруулагдсан байна. | Хан-Уул дүүргийн Засаг даргын А захирамж 2022 оны эхний хагас жилийн байдлаар 1048, ЗДТГ-ын даргын тушаал 349 нийт 1397 захирамжлалын бланк хэвлэгдсэн байна. Нийт захирамжлалын болон зохион байгуулалт, мэдээлэл, лавлагааны 2029 албан бичгийн боловсруулалтад Монгол | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | MNS5140:2011 стандартыг мөрдөн ажиллана. | - | | | | улсын MNS 5140:2021 стандартыг хэрэгжүүлж ажилласан. | |
| 125 | Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны явцад үүсэж хөтлөгдөх, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын шинэчлэн боловсруулж, байгууллагын дэргэдэх БНШК-ын хурлаар батлуулах. | - | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалын батлуулсан эсэх | Засаг даргын Тамгын газрын 2021 онд хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 223 хэрэгтэйгээр шинэчлэн боловсруулж, байгууллагын БНШК-ын 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. | Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны явцад үүсэж хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн боловсруулж, байгууллагын дэргэдэх БНШК-ын хурлаар хэлэлцүүлэн батлуулна. | Дүүргийн хөмрөг үүсгэгч 121 байгууллагын үндсэн болон боломжит эх үүсвэрийн жагсаалтаас 2022-2026 онд нөхөн бүрдүүлэлт хийгдэх байгууллагуудын жагсаалтыг дүүргийн архивын дэргэдэх БНШАЗК-н хурлаар хэлэлцүүлэн баталж, 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 11/886 тоот албан бичгээр Нийслэлийн архивын газрын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар хүргүүлээд байна. | 50% |
| 126 | Төрийн архивт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус нөхөн бүрдүүлэлт хийх хөмрөг үүсгэгч байгууллагын нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж, данс бүртгэлийг дүүргийн архивын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэн батлуулах. | - | Төрийн архивт хөмрөг үүсгэсэн байгууллага, баримтын тоо | БНШАЗК -ын хурлыг 1 удаа хуралдуулсан. | Дүүргийн архивын дэргэдэх БНШАЗК-ын хурлыг зохион байгуулж, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, ажиллана. | Дүүргийн архивын 2022 оны төлөвлөгөөт нөхөн бүрдүүлэлтийн 14 байгууллага, төлөвлөгөөт бус 2 байгууллага нийт 16 байгууллагын архивын баримт, данс бүртгэлийг хянаж, 78 удаа мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгсөн. 5 байгууллагын данс бүртгэлийг БНШАЗК-ын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар хэлэлцэн хүлээн авахаар шийдвэрлэсэн. | 100% |
| 127 | Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын 2021 оны үйл ажиллагааны | - | Хүлээн авсан баримтын тоо | Байгууллагын архивт 580 баримтыг хүлээн авсан. | Баримт бичгийг стандартын дагуу | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадад 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн цаасан суурьт баримтаар байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийг Засаг даргын | 98% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | явцад үүссэн цаасан суурьт болон тусгай төрлийн баримтыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу нягтлан шалгаж хүлээн авах. | | | | архивлаж нөхөн бүрдүүлэлтийг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэсэн байна. | Тамгын газрын даргаар батлуулан, хуваарийн дагуу хэлтэс албадаас 715 хадгаламжийн нэгжийг хүлээн авч баяжилт хийж ажилласан. | |
| 128 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дүүргийн төсөл арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | - | Төсөл арга хэмжээний арга тоо | Хөтөлбөрийн хүрээнд 2 удаагийн цахим аян, 6 удаагийн сургалтад 18826 иргэнийг тус тус хамруулсан. | 3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж, 400 иргэнийг хамруулна. | Жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Гэр бүл дэх тэгш байдал”, “Гэр бүлийн гишүүдийн эрх, үүрэг, оролцоо”, "Харилцан хүндэтгэе” сургалт, мэдээ, мэдээллийг www.khan-uul.mn, www.khanuul.child.gov.mn сайт, " Хан-Уул Эко дүүрэг", "Хан-Уул хүүхэд" болон 21 хорооны албан ёсны цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчилсан.<br>Жендэрийн талаарх ойлголт мэдлэг олгох танхимын 2 удаагийн сургалтад 123 иргэн, бүлгийн зөвлөгөөнд 25 иргэн хамрагдсан.<br>Хан-Уул дүүргийн Жендэрийн салбар хорооноос төрийн захиргааны болон үйлчилгээний 75 байгууллагад "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-д Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5, 11.6, 11.7 дахь хэсгийн зохицуулалтыг тусган баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг хүргүүлсэн бөгөөд 63 байгууллага дотоод журамд тусган, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 100% |
| 129 | Аж, ахуйн нэгж байгууллага болон иргэдийн шагналын асуудлыг хэлэлцүүлэн дэмжүүлж, шагнал гардуулах арга хэмжээг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээ, хамруулсан иргэдийн тоо | 375 иргэнд шагнал гардуулсан. | Шагналын журмын хэрэгжилт хангагдсан байна. | Төрийн болон төрийн бус байгууллага боловсрол, эрчим хүч, хөнгөн үйлдвэрийн салбарт үр бүтээлтэй олон жил ажилласан 476 иргэнийг төрийн дээд одон медалиар шагнуулахаар нэр дэвшүүлсэн материалыг хянан шалгаж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 04, 11 дүгээр тогтоолоор хэлэлцүүлэн батлуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Дүүргийн “Хүндэт тэмдэг”-ээр төрийн болон төрийн бус | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын 51 ажилтан, албан хаагч, иргэдийг шагнасан. Алдарт эхийн 1, 2 дугаар одон авах болзол хангасан 803 эхчүүдийн 31 боть архивын баримтыг НЗДТГ-т хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 69 дүгээр зарлигаар дүүргийн 803 эхчүүд “Алдарт эх”- I, II зэргийн одонгоор шагнагдаж одонгоо гардаж авсан. | |
| 130 | Засаг даргын зөвлөлийн хурлыг журмын дагуу зохион байгуулна. | - | Зохион байгуулсан хурлын тоо, шийдвэрлэлтийн хувь | 45 удаагийн хурал зохион байгуулж 211 асуудлыг хэлэлцсэн. | Шийдвэрийн биелэлтийг тайлагнасан байна. | Засаг даргын зөвлөлийн хурлыг журмын дагуу 20 удаа зохион байгуулж, 141 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн. Тус хурлаас 85 үүрэг даалгавар өгөгдөж хэрэгжилт 75 хувьтай байна. | 100% |
| 131 | Гадаадын зочид төлөөлөгчидтэй холбоо тогтоож, хамтын ажиллагааны хүрээнд санал хүргүүлж, хоёр талын хамтын ажиллагааны уулзалт зохион байгуулна. | - | Санал хүргүүлж, уулзалт зохион байгуулсан эсэх | - | 2-оос доошгүй санал хүргүүлнэ. | Турк Улсын Болгар хот болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хоттой хамтын ажиллагааг сэргээх чиглэлээр шинээр холбоо тогтоох албан хүсэлтийг уламжилж, цахим уулзалт зохион байгуулах тухай санал солилцсон. | 50% |
| 132 | Гадаад, дотоодын байгууллагуудтай гэрээ, санамж бичиг байгуулах ажлыг зохион байгуулна. | - | Гэрээ санамж бичиг байгуулсан эсэх, гүйцэтгэлийн тоо | . | 2-оос доошгүй байгууллагатай гэрээ, санамж бичиг байгуулна. | Дүүргийн Засаг даргын Тамгын газар, “Хаан банк” хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Санамж бичигт дүүргийн нутаг дэвсгэрийн 3*3 сагсан бөмбөгийн талбайг шинээр тохижуулахаар тусгасан. | 100% |
| 133 | Дүүргийн иргэдийг үнэн зөв ил тод шуурхай мэдээ, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна. | - | Иргэдэд хүргэсэн мэдээ, хандалтын тоо | 2985 мэдээ мэдээллийг дүүргийн цахим хуудаснуудад байршуулсан. | Иргэдэд мэдээ, мэдээлэл шуурхай хүрсэн байна. | Монгол Улсын Засгийн газар, дээд байгууллагын хууль тогтоомж, шийдвэрлэлт, нийслэл, дүүргийн үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг иргэдэд үнэн зөв ил тод, түргэн шуурхай хүргэх зорилгоор 3 чиглэлийн албан ёсны фейсбүүк цахим хаяг хөгжүүлж ажиллаж байна. Үүнд: ЗДТГ-ын албан ёсны цахим www.khanuul.mn вэб сайтад нийт 1605 мэдээ, мэдээлэл нийтэлж 495.102 иргэн хандаж, мэдээлэл авсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 134 | Захиргааны актын эрх зүйн үндэслэлийг хянаж, биелэлтийг хагас бүтэн жилээр тооцох. | - | Захиргааны акт хуульд нийцсэн хэрэгжилтийн хувь | Биелэлт 95,7% | Захиргааны акт хуульд нийцэн 95%-иас дээш хэрэгжсэн байна. | Засаг даргын 361 захирамж, ЗДТГ-ын даргын 131 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянан хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн.<br>Засаг даргын 105 захирамжийн биелэлт 88.7% буюу хангалттай хэрэгжсэн. | 100% |
| 135 | Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулах гэрээний үндэслэлийг хянан бүртгэлжүүлэх. | - | Бүртгэлжүүлсэн гэрээний тоо | 471 гэрээг хянаж бүртгэлжүүлсэн | Гэрээ хуульд нийцсэн 100% бүртгэлжүүлсэн байна. | Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын хэлтэс, алба, тасгаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан 306 гэрээний эрх зүйн үндэслэлийн хянан бүртгэлжүүлсэн. | 100% |
| 136 | Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдол, маргаан, нэхэмжлэлтэй холбогдуулан итгэмжлэлийн үндсэн дээр хууль хяналтын байгууллагатай харилцана. | - | Шүүхэд төлөөлсөн үйл ажиллагааны хувь | 24 хэрэг маргаанд оролцсон. | Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 100% төлөөлөн оролцсон байх | Захиргааны хэргийн шүүхэд 16, иргэний хэргийн шүүхэд 1, цагдаагийн байгууллагад 1 нийт 18 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэлийн үндсэн дээр оролцсон.<br>Үүнээс анхан шатны шүүхийн 13, давж заалдах шатны шүүхийн 7, дээд шатны шүүхийн 1 нийт 21 хуралдаанд цахимаар болон танхимаар оролцож:<br>- Иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж гэрээ байгуулахыг даалгасан 2,<br>- Иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 6 | 100% |
| 137 | Хууль тогтоомж, хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг тайлбарлах, эрх зүйн сургалт, сурталчилгааг иргэд, албан хаагчдад зохион байгуулна. | 3.0 | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэд, албан хаагчдын тоо | 14 Сургалт, 1622 иргэд, албан хаагчийг хамруулсан | 8 сургалт зохион байгуулж, 400 иргэн, албан хаагч хамруулах | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан "Хууль, эрх зүйн сургалтын нэгдсэн төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Хуульчдын холбоотой хамтран 5 сургалтыг зохион байгуулж 241 албан хаагч, иргэнийг хамруулсан.<br>Үүнд:<br>Хуульчдын холбоотой хамтран Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн талаарх сургалтыг 2022 оны 02 дугаар сарын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 14, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн талаарх сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 22 өдрүүдэд тус тус зохион байгуулж нутгийн захиргааны байгууллагуудын 140 албан хаагч хамрагдсан.<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхтэй хамтран "Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдал " сэдэвт сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж 35 иргэн хамрагдсан.<br>Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран Цахим гарын үсгийн тухай хуулийн талаарх сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж 35 албан хаагч хамрагдсан.<br>Хуульчдын холбоотой хамтран Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ бусад хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх өдөрлөгийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулж 31 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн. | |
| 138 | Эрх зүйн ажлын тайланг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлнэ. /ХЗДХЯ, ҮАБЗ, НЗДТГ/ | - | Хэрэгжилтийн хувь | 2 удаа тайлан хүргүүлсэн. | Тайланг нэгтгэн хугацаанд нь хүргүүлсэн байна. | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай 2022 онд байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний Хан-Уул дүүрэгт хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг нэгтгэж ЗДТГ-ын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 11/916 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | 100% |
| **ЗУРГАА. БАТЛАН ХАМГААЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ СУРТАЛЧЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **Зорилт 6** Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 139 | Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу Цэргийн бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Цэргийн бүртгэлийн хамрагдалтын хувь | 92,4 хувьтай хэрэгжсэн. | Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу Цэргийн бүртгэлийн үйл ажиллагаа | Хан-Уул дүүргийн 2022 оны цэргийн бүртгэлийг "Цэргийн албаны тухай хууль"-ийн 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны "Цэргийн бүртгэл явуулах тухай" А/331 дүгээр журам, нийслэлийн Засаг даргын 2021 оны А/980, дүүргийн Засаг даргын 2021 оны А/657 дугаар захирамжийг тус тус хэрэгжүүлэн 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 21-ний өдрүүдэд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулагдана. | цэргийн бүртгэлийн ажлыг цахим болон цаасан суурьтайгаар 93,8% зохион байгуулсан. | |
| 140 | Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу 2022 оны ээлжит цэрэг халалт, татлагын үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Цэрэг татлагын арга хэмжээг зохион байгуулсан эсэх, тоон даалгаврыг биелүүлсэн эсэх. | 100 хувьтай хэрэгжсэн. | Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэргийн нөхөн хангах тоон даалгавар биелэгдэнэ. | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/512 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын А/234 дүгээр захирамжийн дагуу 2022 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг Ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн байрыг түшиглэн 2022 оны 05 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулсан. Нийслэлийн Цэрэг татлагын товчооноос өгсөн Хилийн болон Дотоодын цэргийн тоот даалгаврыг 100 хувь биелүүлж, Цэргийн жинхэнэ албанд татагдагсдын **5** хувь нь дээд боловсролтой, **11,6** хувь нь тусгай дунд боловсролтой, **73,3** хувь нь бүрэн дунд боловсролтой, **10** хувь нь бүрэн бус дунд боловсролтой байсан. Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.4 дэх заалтыг үндэслэн 18-25 насны цэргийн үүрэгтнүүдээс 62 өргөдлийг иргүүлж, Цэрэг татлагын товчооны эрүүл мэндийн үзлэгээр оруулж Цэргийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийг үндэслэн ээлжит цэрэг татлагаас түр чөлөөлж шийдвэрлэсэн. | 100% |
| 141 | Дүүргийн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын 18-50 насны цэргийн үүрэгтний Батлан хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтэд үзлэг шалгалт явуулна. | - | Үзлэг явуулсан аж ахуй нэгж байгууллагын тоо | 100 хувьтай 6 ААНБ-ыг шалгасан. | Батлан хамгаалах салбарыг сурталчилсан байна. | 2022 оны эхний хагас жилийн байдлаар Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг дүүргийн Засаг даргын баталсан удирдамжаар зохион байгуулан шалгалтад **5** байгууллагын 18-50 насны **465** цэргийн үүрэгтний нэрсийн жагсаалт /4 дүгээр маягтаар/ авч, **75** хувийг хамруулснаас **37.6** хувь нь зөрчилтэй байсан. 1974-1996 онд төрсөн **6%**-д нь цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр тогтоосноос 6,099,511 төгрөгийг нийслэлийн Төрийн санд төвлөрүүлсэн. Байгууллага, аж ахуйн нэгжид цэргийн үүрэгтний үзлэг шалгалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу явуулснаар иргэний цэргийн зөрчил буурч байна. | 100% |
| 142 | Дайчилгааны тухай хууль, Цэргийн албаны тухай | - | Сургалтуудыг зохион байгуулсан | 2 удаа сургалт | Дайчилгааны бэлтгэл нөөцийн | Цэргийн штабын 2022 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу Дайчилгааны бэлтгэл нөөц болон офицерын сургалтыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуулийн дагуу нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнүүд цэргийн бэлтгэл сургалтуудыг зохион байгуулна. | | эсэх, хамрагдсан цэргийн бэлтгэл үүрэгтний тоо | зохион байгуулсан. | бүрэлдэхүүн, цэргийн дүйцүүлэх алба хаагчдад хууль эрх зүйн болон цэргийн хэргийн мэдлэг олгож, үүрэг гүйцэтгэх дадлага эзэмшүүлсэн байна. | нэгдүгээр шатыг зайн сургалтаар буюу цахимаар, хоёрдугаар шатны сургалтыг ҮБХИС-ийн байнгын байрлалд 2021 оны 10, 11 дүгээр сард зохион байгуулж тус дүүргээс бэлтгэл офицерын дамжаанд иргэд бүрэн хамрагдсан. Сургалтын гуравдугаар шатыг ҮБХИС-ийн хээрийн сургалтын төв "Шархад дах сургалтын полигон"-д 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс 20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Төгсөлтийн арга хэмжээнд Тус дүүргээс хамрагдсан 6 иргэнд бэлтгэл дэслэгч цол, үнэмлэхийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа Г.Ялалт гардуулсан. | |
| 143 | "Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэх" сэдэвт болзолт уралдааныг Өрхийн эрүүл мэндийн төвүүд, нарийн мэргэжлийн их эмч нарын дунд зохион байгуулах, үр дүнг тооцох. | - | Болзолт уралдааныг зохион байгуулан дүгнэж, үр дүнг тооцсон эсэх | 92 хувьтай хэрэгжсэн. | Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдал тодорхой хувиар дээшилсэн байна. | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-ыг үндэслэн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, дүүргийн Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран "Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэх" болзолт уралдааны үр дүнг тооцон ажиллаж байна. | 50% |
| 144 | Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын офицер, ахлагч нарын мэргэжил арга зүйн сургалтад оролцох, дотооддоо батлан хамгаалах хууль, тогтоомжоор сургалт зохион байгуулна. | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. | Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын офицер, ахлагч нарын мэргэжил арга зүйн сургалтад оролцох, дотооддоо | Цэргийн штабын 2022 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу офицер, ахлагч нартай батлан хамгаалах хууль, тогтоомжийн мэдлэг, албан үүргийн гүйцэтгэлийн мэргэжлийн мэдлэг, дадлагыг дээшлүүлэх чиглэлээр сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр дотооддоо зохион байгуулсан.<br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 97 жилийн ойг тохиолдуулан 04 дүгээр сарын 08-ны өдөр Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн байрлалд зохион байгуулагдсан "Нийслэлийн Цэргийн штабын түүхэн замнал, цаашдын чиг хандлага" сэдэвт онолын бага | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | батлан хамгаалах хууль, тогтоомжоор сургалт зохион байгуулагдан а | хуралд Цэргийн штабын офицер, ахлагч нар бүрэн хамрагдсан. | |
| 145 | Дүүргийн Засаг даргын нэрэмжит Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг Боловсролын хэлтэстэй хамтран зохион байгуулна. | - | Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээн зохион байгуулсан эсэх, хамрагдсан сурагчдын тоо | - | Ерөнхий боловсролын 18 сургуулийн ахлах ангийн сурагчдыг хамруулсан байна. | Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жил, Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны 20 жилийн ойг тохиолдуулан дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын цогцолбор **"Дөл"** тэмцээнийг 2022 оны 4 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн байрлалд зохион байгуулсан.<br>Тэмцээний нээлтийн ажиллагаанд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга С.Энхбаяр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын орлогч, хурандаа Б.Эрдэнэпил, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа Г.Жаргалсайхан, дүүргийн Боловсролын хэлтсийн дарга Ж.Отгонхорлоо нар оролцсон.<br>Тэмцээнд дүүргийн Ерөнхий боловсролын нийт 16 сургуулийн 208 сурагчид 14 төрлөөр өрсөлдөж **-7,16** минутаар тэргүүн байрт 7 дугаар сургуулийн **"ХУРД"** баг, **4,72** минутаар дэд байрт 10 дугаар сургуулийн **"АРАВТ"** баг, **6,9** минутаар гутгаар байрт 60 дугаар сургуулийн **"ЦЭГЦ"** баг тус тус эзэлсэн. | 100 |
| 146 | Дүүргийн нутаг дэвсгэрийн төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан албан хаагчид, их дээд сургуулийн оюутнуудад төрийн батлан хамгаалах үйлчилгээг хүргэх, | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 86 хувьтай хэрэгжсэн. | ААНБ-ын ажилтан албан хаагчид, их дээд сургуулийн оюутнуудын хууль эрх зүйн мэдлэг дээшилж, | Дүүргийн Засаг даргын 2022 оны А/41 дүгээр захирамжаар 2022 онд хяналт шалгалт хийхээр батлагдсан дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж 6 байгууллагын хүний нөөцийн мэргэжилтнүүдэд 100 хувь хамрагдсан. "Батлан хамгаалах хууль тогтоомж" сэдвээр 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр цахим сургалтыг зохион байгуулсан. | 40% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | батлан хамгаалах хууль, тогтоомжийг сурталчлах. | | | | төрийн батлан хамгаалах үйлчилгээ авна | | |
| 147 | Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойг угтан Зэвсэгт хүчний анги, байгууллагатай хамтран "Монгол цэргийн бахархал" өдөрлөгийн арга хэмжээг дүүргийн иргэдтэй зохион байгуулна. | - | "Монгол цэргийн бахархал" өдөрлөг зохион байгуулсан эсэх, оролцсон иргэдийн тоо | - | Иргэд, хүүхэд залуучуудын батлан хамгаалах салбарын хууль эрх зүйн мэдлэг дээшилж, эх оронч үзэл төлөвшиж, иргэн-цэргийн харилцаа дээшилнэ | Монгол цэргийн өдөр, Орчин цагийн Зэвсэгт хүчний үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойг тохиолдуулан төлөвлөгөөт 15 ажил төлөвлөснөөс 14 ажил биелэгдэж төлөвлөгөөний хэрэгжилт 93,3 хувьтай биелсэн.<br>Тус арга хэмжээнд Зэвсэгт хүчний анги төрийн цэргийн байгууллага-2, ерөнхий боловсролын сургууль-21 нийт 26 байгууллагатай хамтран ажиллаж, ерөнхий боловсролын сургуулийн 8 багш, 224 сурагч, албан тушаалтан, иргэн 240, нийт 470 гаруй иргэдийг оролцуулж үйл ажиллагааг зохион байгуулсан. | 100% |
| 148 | Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу 2022 оны "Оюутан-цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтын бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулна. | - | "Оюутан-цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулсан эсэх, хамрагдсан оюутны тоо | - | Их, дээд сургуулийн оюутан болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн хугацаат цэргийн алба хаах боломж олгогдоно. | Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/376 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2022 оны А/131 дүгээр захирамжийн дагуу "Оюутан-Цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутны бүртгэлийг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 11-ний өдрийг үндэсний портал сайт E-Mongolia бүртгэлийг хүлээн авсан. 2022 онд дүүргийн хэмжээнд 9 их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 52 оюутан, суралцагчид бүртгэлд хамрагдсан. Эрүүл мэндийн үзлэг, бие бялдаржилтын шалгалтад тэнцсэн 42 оюутныг Үндэсний батлан хамгаалах сургуульд хүлээлгэн өгсөн. | 100% |
| 149 | Орон нутгийн хамгаалалтын хуулийг сурталчлах, Дайчилгаа удирдах бүлэг, цугларах болон шилжүүлэх | - | Томилгоот бүрэлдэхүүний сургалт зохион байгуулагдсан эсэх, | 100 хувьтай хэрэгжсэн | Томилгоот албан тушаалтнуудын үүрэг гүйцэтгэх мэдлэг | Цэргийн штабын 2022 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу 3-р улиралд зохион байгуулна. | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байр, орон нутгийн цэргийн отрядын удирдах бүрэлдэхүүний сургалт зохион байгуулна. | | оролцсон албан тушаалтны тоо | | дадлага дээшилсэн байна. | | |
| 150 | Хорооны Засаг дарга нарын Цэргийн бэлтгэл сургалт зохион байгуулах. | - | Сургалт зохион байгуулагдсан эсэх, ирцийн хувь | - | Хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт хангагдсан байна. | Цэргийн штабын 2022 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу хорооны Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг 3-р улиралд зохион байгуулна. | - |
| 151 | Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг хангасан иргэдийн төлбөр төлөлтөд хяналт тавих, бүртгэл тооцоог хөтлөх. | - | Мөнгөн төлбөрөөр орлуулан хаах иргэдийн хувь, төлсөн мөнгөн дүн | 100 хувьтай хэрэгжсэн. | Батлагдсан нэрсийн жагсаалтын дагуу мөнгөн төлбөрийг барагдуулж, бүртгэл тооцоо хөтлөгдсөн байна. | Цэргийн албаны тухай хуулийн 29.3-д заасны дагуу хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 1994-1996 онд төрсөн 95 иргэнээр 79.3 сая төгрөгийг төлүүлж Нийслэлийн төрийн сангийн 100200000984 тоот дансанд төвлөрүүлж. Эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг гарган Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хүргүүлсэн. | 100% |
| 152 | Цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэнэ. | - | Шилжилт хөдөлгөөний тоо, хувь | 100 хувьтай хэрэгжсэн. | Цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн шилжилт хөдөлгөөн бүртгэгдэнэ. | 2022 оны эхний хагас жилийн байдлаар шилжилт хөдөлгөөний журмын дагуу шилжсэн-74, тус дүүрэгт шилжин ирсэн-218 иргэнийг бүртгэж, цэргийн бүртгэлийн мэдээллийн санд оруулсан. | 100% |
| 153 | Монгол Улсын Дайчилгааны хуулийн дагуу Зэвсэгт хүчний анги, байгууллагатай хүн, техникийн дайчилгааны тодотгол явуулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт хувь | 85 хувьтай хэрэгжсэн. | Зэвсэгт хүчний анги, байгууллагатай явуулах дайчилгааны тодотгол хийгдэнэ | Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө, орон нутгийн цэргийг байгуулах бэлтгэлийг хангах төлөвлөгөөнүүдэд тодотголыг хийж үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. | 20% |
| 154 | Цэргийн албаны тухай хуулийн дагуу цэргийн дүйцүүлэх албанд иргэдийг | - | Зохион байгуулсан сургалт, | 100 хувь хэрэгжсэн. | Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журмын | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 220 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | элсүүлж, сургалт зохион байгуулна. | | хамрагдсан иргэдийн тоо | | дагуу иргэдийг сонгон дүйцүүлэх албанд элсүүлж, үүрэг гүйцэтгүүлнэ. | А/771, дүүргийн Засаг даргын 2022 оны А/324 дүгээр захирамжаар дагуу 2022 онд цэргийн дүйцүүлэх албанд элсэхээр хүсэлт гаргасан 6 иргэнийг судалж, цэргийн дүйцүүлэх албанд элсүүлсэн.<br>Дүүргийн Засаг даргын 2022 оны А/325 дугаар захирамжаар цэргийн дүйцүүлэх албыг биеэр 24 сар алба хааж хугацаа дуусгасан 10 иргэнийг халж Засаг даргын Тамгын газрын дарга С.Энхбаяр талархал цэргийн үүрэгтний үнэмлэхийг 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдөр гардуулсан. | |

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ЗАСАГ ДАРГЫН НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ .............................. Б.ЦЭРЭН

ТАМГА 2022-06-29
(огноо)

ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАГНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА .............................. С.ЭНХБАЯР

ТАМГА 2022-06-28
(огноо)